



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нийслэлийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2023/28-11-ШТА-ГА) тайлан, акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумьяабазар), Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар (Г.Энхтайван), Нийслэлийн Боловсролын газар (Б.Амартүвшин), Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар “ОНӨААТҮГ” (Б.Мөнхбат)-т зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг гүйцэтгэл-нийцлийн хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Нийтийн тээврийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар “ОНӨААТҮГ”-т тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ


002010154



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, ХАА зохион байгуулах, гүйцэтгүүлэх, шат шатны хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг бүрэн мөрдөөгүйгээс өмнөх жилүүдэд гарсан зөрчлүүд дахин давтагдаж байна.



**АУДИТЫН СЭДЭВ: НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот  
2023 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	3
	Хүснэгтийн жагсаалт	4
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Графикийн жагсаалт	4
Гүйцэтгэл-нийцлийн хэлтэс	Хавсралтын жагсаалт	4
Хэлтсийн дарга, аудитын менежер:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
 Э.Мөнхмандах		
Аудитын менежер:	Ерөнхий мэдээлэл	6
 Л.Саранбаатар	В.1 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх	7
Аудитор:	В.1.1 Төсөл, арга хэмжээ нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?	7-8
 Д.Дариймаа		
 М.Одгэрэл	В.1.2. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?	8-14
 Б.Батбилгүүн	В.2 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх	15
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787	В.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?	15-20
Тайланг НТАГ-ын <a href="http://www.audit.mn/">http://www.audit.mn/</a> веб сайтаас үзнэ үү.	В.2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?	20-29
	В.2.3. Санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон уу?	29-32
	В.2.4 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	32-33
	В.2.5 Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?	33-34
	Аудитын дүгнэлт	35
	Аудитын зөвлөмж	36
	Холбогдох байгууллагын санал	37-38
	Саналд өгсөн тайлбар	39
	Хавсралтууд	40-76

## Товчилсон үг

УИХ	Улсын Их хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн газар
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ГУББГ ОНӨААТҮГ	Геодези, усны барилга байгууламжийн газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗТГ ОНӨААТҮГ	Зорчигч тээвэр гурав
ЗХУТ	Замын хөдөлгөөний удирдлагын төв
ЗҮ	Зөвлөх үйлчилгээ
НАЖГ	Нийслэлийн аялал жуулчлалын газар
НБОГ	Нийслэлийн байгаль орчны газар
НД	Налайх дүүрэг
НИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НОСБГ	Нийслэлийн орон сууцны бодлогын газар
НОСК	Нийслэлийн орон сууцны корпорац
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
УБЗАА	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
НБГ	Нийслэлийн Боловсролын газар
НГЗБА	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
НЗД	Нийслэлийн засаг дарга
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТХО	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НЦХМТГ	Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НХОГ	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар
ННТУГ	Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
НЦУГ	Нийслэлийн цагдаагийн удирдах газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБ	Улаанбаатар
УБЗЗАГ ОНӨААТҮГ	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар
УБХАЗТБНТХНэгж	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
ОНӨТҮГ	Улаанбаатар хөгжлийн корпорац
УБХК	Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт
УБШББ ХХК	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн
ҮЦХ	Худалдан авах ажиллагаа
ХАА	Хот тохижилтын газар
ХТГ	Хот төлөвлөлт, судалгааны институт
ХТСИ	Хан-Уул дүүрэг
ХУД	Чингэлтэй дүүрэг
ЧД	Төсөл, арга хэмжээ
ТАХ	Тендер шалгаруулалтын онцгой журам
ТШОЖ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн аж ахуйн тооцоот үйлчилгээний газар
ОНААТҮГ	Эмээлт эко аж үйлдвэрийн парк
ЭЭАҮП	

## **Хүснэгтийн жагсаалт**

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
Хүснэгт №1	Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлтийн жагсаалт	8
Хүснэгт №2	Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд иргэдээс ирүүлсэн санал	9
Хүснэгт №3	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ	10
Хүснэгт №4	Авто замын түгжрэл бууруулах ТАХ-г ерөнхий нэрээр баталсан байдал	11
Хүснэгт №5	Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ” ТАХ-ны задаргаа	11-12
Хүснэгт №6	Зураг төсөвгүй ТАХ	12
Хүснэгт №7	Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлгүй ТАХ	12
Хүснэгт №8	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	13
Хүснэгт №9	Төрийн хэмнэлтийн тухай хууль, журамд нийцээгүй ТАХ	14
Хүснэгт №10	Эрх шилжүүлж, ХАА зохион байгуулсан	15
Хүснэгт №11	ХАА-нд мөрдсөн журам	17
Хүснэгт №12	ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа нэршил, байршил, хүчин чадал зэргийг нарийвчлан төсөвт өртгийг задлах, хуваасан бөгөөд багцалсан ТАХ	19
Хүснэгт №13	Цэцэрлэгийн хүртээмж, нэмэгдүүлэх тоног, төхөөрөмж тавилга хэрэгсэл	19
Хүснэгт №14	ТАХ-ний гэрээний хэрэгжилт	20
Хүснэгт №15	Авто замын түгжрэл бууруулах” ТАХ-ний гэрээний хэрэгжилт	21
Хүснэгт №16	ТАХ-ний санхүүжилт	29
Хүснэгт №17	Бодит гүйцэтгэлд үндэслээгүй илүү олгосон ТАХ	30
Хүснэгт №18	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан ТАХ-ний жагсаалт	30-31
Хүснэгт №19	Ажил гүйцэтгэлд үндэслээгүй, хяналтын зардал гаргасан ТАХ	31
Хүснэгт №20	Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй	31
Хүснэгт №21	Төсөвт өртөг нь нэмэгдсэн ТАХ	32

## **Хавсралтын жагсаалт**

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
Хавсралт №1	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино хугацааны баримт бичигт нийцээгүй баталсан ТАХ-ний жагсаалт	40
Хавсралт №2	НИТХ-ын 2021.12.03-ны 11/34 дүгээр тогтоолд батлагдсан саналд үндэслээгүй ТАХ-ний жагсаалт	41
Хавсралт №3	Өмчлөлд шилжих боломжгүй ТАХ-ний жагсаалт	42
Хавсралт №4	Ерөнхий нэрээр баталсан ТАХ-ний жагсаалт	43
Хавсралт №5	Нийслэлд авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд 2022 онд шинээр хэрэгжүүлэх 7 багц ТАХ-г захирамжаар задалсан байдал	43
Хавсралт №6	Зураг техникийн нөхцөлгүй баталсан ТАХ	49
Хавсралт №7	Газаргүй буюу холбогдох зөвшөөрөлгүй батлагдсан ТАХ	55
Хавсралт №8	Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ	55
Хавсралт №9	Төрийн хэмнэлтийн тухай хууль, журамд нийцээгүй ТАХ	59
Хавсралт №10	Эрх шилжсэнээс хойш 100-с дээш хоног хоцорсон байгуулсан үнэлгээний хороо, ХАА	67
Хавсралт №11	ХАА-г 5-10 удаа зохион байгуулсан	69
Хавсралт №12	Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн жагсаалт	70
Хавсралт №13	ТББ-т тусгасан зарим шаардлага хангаагүй гүйцэтгэгчдийн жагсаалт	72
Хавсралт №14	Тендер шалгаруулалтын онцгой журмаар шалгаруулсан ТАХ	72
	Шууд захирамжаар эрх шилжүүлсэн ТАХ	76

## **Графикийн жагсаалт**

<b>Дугаар</b>	<b>Гарчиг</b>	<b>Хуудас</b>
График №1	ТАХ-нд эзлэх хувийн жин, төрлөөр	16

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Аудитын зорилт, хамрах хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, НТАГ-ын 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.</p>
Аудитын зорилт	<p>Орон нутгийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p>
Аудитын хамарсан хүрээ	<ul style="list-style-type: none"> <li>○ Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх;</li> <li>○ Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх;</li> </ul> <p>Аудитыг НЗДТГ, УБ хотын ЗАА, НХААГ, НЗХГ, НБГ, НХБХГ, ННТҮГ, НӨХГ, НЭМГ, НЦХМТГ НХОГ “ОНӨААТҮГ”, ХТГ “ОНААТҮГ” “Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” болон харьяа газрууд болон 2022 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдийг түүвэрлэн гүйцэтгэлээ.</p>
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	<p>Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, аудитор Д.Дариймаа ахалж, аудитор М.Одгэрэл, Б.Батбилгүүн нар гүйцэтгэв.</p>
Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл	<p>Аудитыг 2023 оны 1 дүгээр сарын 30-аас 3 дугаар сарын 22-ны өдрүүдэд гүйцэтгэх ба тайлагналын үе шатны ажлыг 2023 оны 3 дугаар сарын 23-ний өдөр эхлүүлж аудитын тайланг НТАГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2023 оны 4 дүгээр сарын 20-нд УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, НИТХ, НЗД, НХААГ, НХОГ, НЗХГ-т хүргүүлнэ.</p> <p>Аудитад хамрагдагч, шалгагдагч зарим байгууллага нь 2022 оны баримтыг архивын нэгж үүсгээгүй байсан нь талбарт ажиллах, баримт материал татах, тулган баталгаажуулахад хүндрэл бэрхшээлтэй байсан.</p>

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11/34 дугаар тогтоолоор Нийслэлийн 2022 оны төсвийг баталсан.

Тогтоолын 2, 5, 6 дугаар хавсралтуудаар 2022 онд шинээр хэрэгжих болон өмнөх оноос дамжин хэрэгжиж байгаа 1,412,527.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 211 багц ТАХ-г тухайн онд 726,671.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан. Үүнд:

- 1,213,479.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламжийн 152 багц ТАХ,
- 26,895.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын 24 багц ТАХ,
- Өмнөх онуудаас дамжин хэрэгжиж буй 172,152.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 35 ТАХ.

Дээрх 11/34 дугаар тогтоолд /2022.06.22, 2022.12.02/ нийт 2 удаа нэмэлт өөрчлөлт орж, ТАХ-ний тоог 179 багц, төсөвт өртгийг 1,345,953.7 сая төгрөг, тухайн онд санхүүжих дүнг 594,403.9 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. 2022 онд хэрэгжих ТАХ-нд орсон өөрчлөлтийг харуулбал:

- 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор ТАХ-г 185 болгож 26 багц ТАХ-ээр бууруулж, батлагдсан төсөвт өртгийг 1,406,730.6 сая төгрөг болгон тодотгож, тухайн онд санхүүжих дүнг 594,403.9 сая төгрөг болгон бууруулсан.
- 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 111 дугаар тогтоолоор нийт ТАХ-г 179 багц буюу 6 ТАХ-ээр бууруулж, төсөвт өртгийг 1,345,953 сая төгрөг болгон тодотгож, тухайн онд санхүүжих дүнг 594,403.9 төгрөгөөр бууруулжээ.

Тодотголоор баталсан 179 багц ТАХ-ээс 79 багц ТАХ нь өмнөх онуудаас хэрэгжиж байгаа, 100 багц ТАХ нь шинээр хэрэгжиж буй ТАХ байна.

НЗД-аас ТАХ-г худалдан авах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ нэршил, байршил, хүчин чадал зэргийг нарийвчлан ТАХ-ний төсөвт өртгийг задлах, хуваах байдлаар шилжүүлсэн нь НИТХ-ын тогтоолд батлагдсан 179 багц ТАХ-ний тоон дүнг нь задлаад 644 ТАХ болсон байна.

НЗД 2022 онд харьяа 37 газарт 233 удаагийн захирамжаар 763,177.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 673 ТАХ-ний ХАА-ны эрхийг шилжүүлсэн.

Эрх шилжсэн 763,177.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 673 ТАХ-ээс нийслэл дүүргийн худалдан авах ажиллагааны газарт 536 ТАХ буюу 80%, ОНӨААТҮГ-т 108 ТАХ буюу 16%, бусад харьяа газруудад 29 ТАХ буюу 4%-ийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин болон 2022 онд шинээр эхэлсэн нийт 970,784.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 659 ТАХ-д “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, НБГ, НЗДТГ, ЗАА, НӨХГ, НХБХГ, НГЗБА, НЦХМТГ, ННТГ, УСУГ, УБ-Лифт зэрэг 32 газраас захилагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Дээрх ТАХ-нүүдээс 374,800.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 345 ТАХ буюу 53.6% нь хэрэгжиж дууссан, 312,697.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 233 ТАХ буюу 36.2% нь дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Харин 21,451.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 19 ТАХ буюу 2.9% нь 2022 онд хэрэгжиж эхлээгүй байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжих болон шинээр хэрэгжих 1,345,953.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 179 багц ТАХ-нд /800 гүйцэтгэгч байгууллага/ 2022 онд 611,414.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 550 гүйцэтгэгчид 391,223.0 сая төгрөг буюу 64.0%-ийн санхүүжилт олгожээ. Үүнээс он дамжин санхүүжих 28 багц ТАХ /163 гүйцэтгэгч байгууллага/-нд гүйцэтгэлээр 35,971.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

## В.1 ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ҮҮ?

### В.1.1 Төсөл, арга хэмжээ нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан уу?

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын баримт бичгийг 9 зорилго, 47 зорилт, 73 шалгуур үзүүлэлтээр 3 үе шатанд / I үе шат 2021-2030 он, II үе шат 2031-2040 он, III үе шат 2041-2050 он/ хэрэгжүүлэхээр баталсан.

Төсвийн тухай хуулийн 12.1.4<sup>1</sup>, 6.5<sup>2</sup>, 67.3<sup>3</sup> дахь заалт, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-үүдэд үндэслэн НИТХ-аас Нийслэлийн 2022 оны төсвийг баталсан.

#### Хүснэгт №1. Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлтийн жагсаалт

(сая.төг)

№	Нэр, батлагдсан он, сар, өдөр, дугаар	ТАХ хэрэгжих он	Тогтоолын Батлагдсан			Өсөлт / бууралт		
			тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	“Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай” 2021.12.03-ны өдрийн 11/34 дугаар	Он дамжих	88	460,877.0	118,420.9	-	-	-
		2022 онд хэрэгжих	123	951,650.3	608,250.8	-	-	-
		<b>НИЙТ</b>	<b>211</b>	<b>1,412,527.2</b>	<b>726,671.7</b>	-	-	-
2	“Нийслэлийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022.06.22-ны өдрийн 65 дугаар	Он дамжих	81	441,899.1	97,555.1	(7)	(18,977.9)	(20,865.8)
		2022 онд хэрэгжих	104	964,831.5	496,848.8	(19)	13,181.3	(111,402.0)
		<b>НИЙТ</b>	<b>185</b>	<b>1,406,730.6</b>	<b>594,403.9</b>	<b>(26)</b>	<b>(5,796.6)</b>	<b>(132,267.8)</b>
3	“Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 65 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2022.12.02-ны өдрийн 111 дугаар	Он дамжих	79	428,799.2	98,572.6	(2)	(13,099.9)	1,017.5
		2022 онд хэрэгжих	100	917,154.5	495,831.3	(4)	(47,677.0)	(1,017.5)
		<b>НИЙТ</b>	<b>179</b>	<b>1,345,953.7</b>	<b>594,403.9</b>	<b>(6)</b>	<b>(60,776.9)</b>	-

2022 оны төсөв баталсан НИТХ-ын тогтоолд нэмэлт өөрчлөлтүүд орж анх төлөвлөснөөс 32 багц ТАХ /2022 онд шинээр хэрэгжих/ хасагдаж, төсөвт өртөг нь 47,677.0 сая төгрөгөөр буурсан байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө МУ-ын хөгжлийн бодлогын урт хугацааны баримт бичиг болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбрийн зорилго, зорилтод нийцүүлж, нийслэлд хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний үр ашгийг тооцон, хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигүүдтэй уялдуулан төлөвлөсөн байна.

### В.1.1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь “НЗД-ын 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй нийцэж байна уу?

<sup>1</sup>12.1.4.жилийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийг төсвийн цаглаврыг баримтлан бэлтгэж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;

<sup>2</sup> 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

<sup>3</sup> 67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

НИТХ-ын 2021 оны 11/34 тогтоолд шинээр хэрэгжүүлээр баталсан 951,650.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 123 ТАХ-г нийслэлийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг тулган баталгаажуулахад “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд 112 багц ТАХ буюу 91.0%-ийг нийцүүлж, 100,316.6 сая төгрөгийн төсөвт 13 багц ТАХ буюу 10.5%-ийг нийцүүлээгүй төлөвлөж батлуулсан байна. **Хавсралт №1**

**Дүгнэлт:** 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 123 багц ТАХ-нээс 91.0%-ийг хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичигт нийцүүлэн баталсан байна.

### **В.1.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг “Нийслэлийг хөгжүүлэх 2022 оны хөгжлийн төлөвлөгөө”-тэй нийцүүлэн төлөвлөсөн үү?**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9<sup>4</sup>-д богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар тусгасан.

Дээрх хуулийн 18.6<sup>5</sup>-д заасны дагуу орон нутгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөг тухайн жилийн 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлахаар заасан ч тус заалтыг мөрдөөгүй, 2 сарын хугацаа хоцроож дараа жилийн төсөвтэй хамт баталсан байна. Үүнд:

- НИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ний 11/31 дүгээр тогтоолоор “Нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө”-г баталсан;
- Мөн өдрийн 11/34 тогтоолоор “Нийслэлийн 2022 оны төсөв”-ийг баталсан байна.

Цаглабарын хувьд хөгжлийн бодлогын богино хугацааны баримт бичиг, нийслэлийн төсөв батлах тогтоолууд нэг өдөр батлагдсан учир дараа жилд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ нь хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байсан.

**Дүгнэлт:** Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хугацаа хоцроож баталсан нь хөрөнгө оруулалтын ТАХ нь хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

### **В.1.2 Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?**

2022 онд хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.4.5, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 , 4.1.27 , 6 дугаар зүйлийн 6.6.5 , 6.6.6 дахь заалтууд, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсгийг баримтлаагүй байна.

ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, зураг төсөв батлагдаагүй, техникийн нөхцөл, газрын асуудал шийдвэрлэгдээгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай зэрэг ТАХ-г төлөвлөсөн байна.

#### **В.1.2.1 ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн үү?**

<sup>4</sup> 6.9 Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна;

<sup>5</sup> 18.6. Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал аймаг, нийслэл, хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар 01-ний дотор батална.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5<sup>6</sup> дахь заалтын дагуу ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналыг харгалзан үзэхээр тусгасан.

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх ТАХ-г ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн эсэхийг шалгахад дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8<sup>7</sup> дугаар зүйлд заасны дагуу НЗД-ын 2021 оны 01/4047 дугаар албан бичгээр нийслэлийн харьяа 92 байгууллагаас 2022 оны нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлагатай 3,018,900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 896 ТАХ-ний санал авснаас 33.9% буюу 8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 98 багц ТАХ-г нийслэлийн 2022 оны төсөвт тусгасан.
- Нийслэлд 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр НИТХ-ын тогтоолоор баталсан 951,650.3 сая төгрөг өртөгтэй 123 багц ТАХ-г олон нийтийн саналд үндэслэсэн эсэхийг тулган баталгаажуулахад 81.3% буюу 849,596.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 багц ТАХ-г саналд үндэслэсэн, 23 багц буюу 18.6%-нь үндэслээгүй байна. **Хавсралт №2**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2<sup>8</sup> дахь заалтын дагуу 2021 оны 11 дүгээр сарын 18-22-ны өдрүүдэд /Ковид-19 халдварт цар тахлаас шалтгаалж/ [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудсаар иргэдэд танилцуулж, санал авахад нийслэлийн 9 дүүргийн 262 иргэн хандаж, давхардсан тоогоор 266 санал өгсөн байна. Энэ нь УБ хотод оршин сууж буй 18-аас дээш насны нийт 1,028,337<sup>9</sup> иргэдээс 0.03%-ийг эзэлж байна.

**Хүснэгт №2. Нийслэлийн 2022 оны төсвийн төсөлд иргэдээс ирүүлсэн санал**

№	Иргэдийн саналаар ангилж, эрэмбэлэгдсэн жагсаалт	Иргэдийн		ТАХ-ний тоо	Эрэмбэлэгдсэн жагсаалт
		Тоо	Саналын тоо		
1	Нийтийн тээвэр	90	92	7	7
2	Гэр хорооллын дахин төлөвлөлт	43	44	21	4
3	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	32	32	3	9
4	Авто зам барих, засварлах	23	23	58	2
5	Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилт	22	22	28	3
6	Үерийн хамгаалалтын барилга	17	17	5	8
7	Ус түгээх байр	12	12	2	10
8	Орон сууцны дээвэр, цахилгаан шатны засвар	11	11	19	5
9	Гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамж	8	9	12	6
10	Бусад /инженерийн байгууламж, гарааш хайс буулгах, тоног төхөөрөмж, телекамер, уулзвар дахин инженерчлэх гэх мэт/	4	4	219	1
<b>НИЙТ ДҮН</b>		<b>262</b>	<b>266</b>	<b>374</b>	

Иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлсэн байдлыг авч үзэхэд нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх санал хамгийн их буюу 92 байхад 7 дугаарт жагсаасан, гэр хорооллын дахин төлөвлөлт 43 санал авсан байхад 4 дүгээрт жагсаасан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажил 32 санал авсан байхад 9 дүгээрт жагсаасан зэргээр иргэд олон нийтийн саналыг харгалзан үзээгүй байна.

<sup>6</sup> 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

<sup>7</sup> Төсвийн цаглавар

<sup>8</sup> 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

<sup>9</sup> Нийслэлийн Статистикийн газар

<sup>9</sup> 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

Цаашид ТАХ-ний талаарх мэдээллийг иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, мөн НТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 дахь заалтад нийцүүлсэн журам боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болжээ.

**Дүгнэлт:** Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих ТАХ-г төлөвлөхдөө хэрэгжүүлэх дараалал, ач холбогдолоор нь эрэмблээгүй, олон нийтийн саналд үндэслээгүй байна.

### ***В.1.2.2 Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн үү?***

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24<sup>10</sup>-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ нь тухайн шатны төсөвт хамаарах этгээдийн өмчлөлд бүртгэгдэх зарлага байдаг.

2022 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 79,387.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ өмчид бүртгэгдэхгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай орон сууцны засвар, цахилгаан шатны шинэчлэлт, чадавхын сургалт, магадлан шалгалт, сургалтын бэлтгэл зэрэг ажил байна. **Хавсралт №3** Тухайлбал:

#### **Хүснэгт №3. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ**

№	ТАХ-ний нэр	Хугацаа		Төсөвт өртөг (сая.төг)
		Эхлэх	Дуусах	
1	Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлж, чадваржуулах, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ /Улаанбаатар хот/	2022	2022	1,200.0
2	Төвийн бүсийн 5 дахь эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд 300 МВт-ын цахилгааны станц барьж байгуулах төслийн хуулийн магадлан шалгалт	2022	2022	20.0
3	Нийслэл Улаанбаатар хотын зээлжих зэрэглэлийг тогтоох бэлтгэл ажил	2022	2022	150.0
4	Гадна фасадын засварын ажил (БЗД, 8 дугаар хороо)	2022	2022	35.2
5	27 дугаар байрны цахилгаан шат шинэчлэх ажил (БГД, 15 дугаар хороо)	2022	2022	140.0
6	Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр, фасадын засвар /Улаанбаатар хот/	2022	2022	1,800.0
<b>НИЙТ</b>				<b>3,345.2</b>

**Дүгнэлт:** Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус зарим төсөл, арга хэмжээг төлөвлөж, баталсан байна.

### ***В.1.2.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгасан уу?***

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусган баталж, хэрэгжүүлэхээр заажээ.

Нийслэлийн 2022 оны төсвийн тодотголоор шинээр хэрэгжүүлэхээр баталсан 179 багц ТАХ-ээс 79 багц ТАХ нь өмнөх онуудаас дамжин хэрэгжиж байгаа, 100 багц ТАХ нь шинээр хэрэгжиж буй ТАХ байна.

#### **Ерөнхий нэрээр баталсан:**

2022 онд төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 917,154.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 багц ТАХ-нээс 561,766.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 78 ТАХ-г нэр байршил нэг бүрээр тусгасан.

<sup>10</sup> 4.1.24."хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

Харин 356,465.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих дүнгээр 245,985.0 сая төгрөгийн 22 багц ТАХ-г Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4<sup>11</sup>, 29.4<sup>12</sup> заалтыг зөрчиж ерөнхий нэршлээр буюу хууль, журамд заасан шаардлагыг бүрэн хангаагүй баталсан байна. Эдгээр 22 багц ТАХ-г хэрэгжүүлэх шатанд НЗД-ын захирамжаар 468 ТАХ задалж, хэрэгжүүлэх байршил, ТАХ-ний төсөвт өртгийг тодорхой болгосон байна. **Хавсралт №4** Тухайлбал:

- “Нийслэлд хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилт, их засварын ажил” /Улаанбаатар хот/ 7,682.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, захирамжаар 41 ТАХ болж задарсан;
- “Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, 9ш” /Улаанбаатар хот/ 48,857.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, захирамжаар нэр байршил тодорхойлон 9 ТАХ болж задарсан;
- “Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэлт” /Улаанбаатар хот/ 1,301.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, захирамжаар 10 ТАХ болж задарсан;
- “Авто зогсоол, явган болон дугуйн зам, тохижилт ногоон байгууламж” 20,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, захирамжаар 8 ТАХ болж задарсан.

Тухайлбал: НИТХ-ын 2022 оны төсөв баталсан тогтоолд автозамын түгжрэл бууруулах 5 чиглэлийн 47 багц бүхий ТАХ тусгасан. Үүнээс 564,888.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ-г нэр, байршил нэг бүрээр тусгасан. Харин **272,116.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 багц ТАХ-г** ерөнхий нэршлээр тусгасан. Энэ 7 багцийн ажлыг НЗД-ийн захирамжаар 276 ТАХ болгон задалсан. **Хавсралт №5**

**Хүснэгт №4. Авто замын түгжрэл бууруулах ТАХ-г ерөнхий нэрээр баталсан байдал**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	Задалсан тоо
		Эхлэх	Дуусах			
1	Уулзваруудын дахин инженерчлэл	2022	2022	4,500.0	4,500.0	2
2	Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем	2022	2022	22,300.0	22,300.0	21
3	Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт	2022	2023	77,260.4	76,195.4	2
4	Граж, хайс хашлага буулгаж, чөлөөлсөн газар дээрх нөхөн сэргээлт хийх, явган зам, ногоон байгууламжийн барилгын ажил, зөвлөх үйлчилгээ	2022	2022	16,705.0	16,705.0	2
5	Авто зогсоол, явган болон дугуйн зам, тохижилт ногоон байгууламж	2022	2023	20,000.0	15,000.0	8
6	Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ /Улаанбаатар хот/	2022	2023	82,764.0	60,348.0	232
7	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, 9ш /Улаанбаатар хот/	2022	2024	48,587.0	5,600.0	9
<b>НИЙТ</b>				<b>272,116.4</b>	<b>200,648.4</b>	<b>276</b>

Тухайлбал: “Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ”-ний хүрээнд ерөнхий нэрээр баталсан 2 ТАХ нь 241 ТАХ болгон задарсан байна.

**Хүснэгт №5. Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ” ТАХ-ны задаргаа**

№	Төсөл, арга хэмжээний төрөл	НЗД -ын захирамжаар задарсан тоо	Батлагдсан төсөл, арга хэмжээний			
			Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	Цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор	11	2022	2022	7,120.3	7,120.3
2	Бие даасан барилга	16	2022	2024	62,710.4	18,113.4
3	Иж бүрэн гэр цэцэрлэг	6	2022	2022	325.3	325.3
4	Орон сууцны I давхар	13	2022	2023	18,977.0	17,977.6
5	Сургууль, цэцэрлэгийн барилга	5	2022	2023	10,189.4	6,839.6
6	Цэцэрлэгийн засвар	32	2022	2022	2,946.2	2,946.2

<sup>11</sup> 29.3.4. санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

<sup>12</sup> 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

7	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга	5	2022	2024	18,762.2	4,200.0
8	Цэцэрлэгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж	141	2022	2022	6,878.5	6,878.5
9	Тоглоом худалдан авах	12	2022	2022	399.0	399.0
10	Захирамжлаагүй үлдэгдэл				3,042.7	1,148.1
	<b>Нийт</b>	<b>241</b>	<b>2022</b>	<b>2024</b>	<b>131,351.0</b>	<b>65,948.0</b>

**Төсвийн тухай хуулийн 29 дүгээр 29.4<sup>13</sup>-д заасныг зөрчин зураг төсөвгүй баталсан ТАХ. Хавсралт №6.**

Шинээр хэрэгжүүлэх нийт 310 ТАХ-ээс 123 буюу 39.6%-д нь зураг төсөв шаардагдах ТАХ байна. Үүнээс 19 буюу 15.5% нь зураг төсөвтэй, 104 буюу 84.5%-г зураг төсөвгүй байна.

**Хүснэгт №6. Зураг төсөвгүй ТАХ**

(сая.төг)

ТАХ-ний тоо	Зураг төсөв шаардагдах		Үүнээс зураг төсөвгүй батлагдсан		
	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
123	344,156.2	256,388.2	104	148,397.9	148,397.9

1. Дээрх 310 ажлаас 54-д зураг газрын зөвшөөрөл шаардлагатай байна. Эдгээрээс 47 ТАХ-нд газар чөлөөлөлт хийгдэх буюу газрын зөвшөөрөлгүй баталжээ. **Хавсралт №7**

**Хүснэгт №7. Газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлгүй ТАХ**

(сая.төг)

ТАХ-ний тоо	Газрын зөвшөөрөл шаардагдах		Үүнээс газар чөлөөлөлт дуусаагүй		
	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
54	116,778.6	52,976.2	47	69,497.6	48,976.2

Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажиллагааг бүрэн хангаагүй буюу зураг төсөвгүй, газаргүй ТАХ-г төсөвт суулгаснаас шалтгаалж хэрэгжилтийн үе шатны ажил удааширч ТАХ-ний хэрэгжих хугацаанд нөлөөлсөн байна. Тухайлбал:

- **Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто замын гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол барих ажил.** ТАХ-нд гүйцэтгэгчтэй 2022.12.22-нд гэрээ байгуулсан. Тухайн замын трасст 283 нэгж талбар өртсөн замын нөлөөлөлөөс 208 нэгж талбарыг чөлөөлж, 27,046.2 сая төгрөгийн нөхөх олговор олгосон хэдий ч хүйтний улиралд гэрээ байгуулсанаас шалтгаалан ажил эхлээгүй удааширсан байна.
- **Хувьсгалчдын гудамжнаас 105 дугаар сургууль, Гүнжийн нуурыг дайраад 7 дугаар хорооны авто зам хүртэлх авто замын үргэлжлэл /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 7, 8, 11 дүгээр хороо/ Тухайн замын трасст 19 нэгж талбарын газар чөлөөлөлт хийгдэж, 199,2 сая төгрөгний нөхөх олговор олгосон ч газар чөлөөлөлт оройтож хийгдсэний улмаас хүйтний улиралд ажил эхэлсэн байна.**
- **Дунд голын арын Алтай хотхоны урд талын авто зам барих ажил.** Зам барилгын ажлын хүрээнд шинэчлэгдэх бохирын шугамын трассаар орон сууцны хорооллын дулааны шугам хийгдсэн байсан нь замын ажил эхлэх боломжгүй болгосон байна.
- **Сургуулийн барилга 640 суудал /СХД 30 дугаар хороо/ Газрын зөвшөөрөлгүй батлагдсан.** Барилга барих газарт 40 нэгж талбарыг чөлөөлөлхөөс 25 нэгж талбарыг чөлөөлсөн байна.
- 11 байршилд **“Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор”** барих зураг төсөвгүй батлагдаж, гүйцэтгэгчидтэй гэрээг оройтож байгуулсанаас шалтгаалан

<sup>13</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

хүйтний улиралд ажил эхэлж, гүйцэтгэсэн гэрийн суурь хөлдөх зэрэгээр шалтгаалж ТАХ-ний хэрэгжих хугацаа удааширсан байна.

**Дүгнэлт:** Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангуулаагүй байна.

### **В.1.1.3 Төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулсан уу?**

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх 401,621.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 1.3-18,119.7 сая төгрөгөөр дутуу, нийт 87,053.0 сая төгрөгөөр дутуу баталжээ. **Хавсралт №8**

#### **Хүснэгт №8. Тухайн онд санхүүжих дүнг дутуу баталсан ТАХ**

№	Салбар	ТАХ-ний тоо	Батлагдсан		Санхүүжих дүнгийн зөрүү	
			Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Тэнцүү хуваарилах дүн	Дутуу дүн
1	Барилга байгууламж	30	250,960.4	42,433.6	103,195.7	60,752.2
2	Гол болон туслах зам	2	110,575.0	15,200.0	36,858.3	21,658.3
3	Засвар	3	3,500.0	1,248.7	1,750.0	501.3
4	Зураг төсөл	5	7,936.2	4,077.8	5,694.2	1,616.4
5	Бусад	3	28,649.5	11,800.0	14,324.8	2,524.8
	<b>НИЙТ</b>	<b>43</b>	<b>401,621.1</b>	<b>74,760.1</b>	<b>161,823.0</b>	<b>87,053.0</b>

Дээрхи 43 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 21.6%-иар дутуу баталсан нь зураг төсөвгүй, газаргүй ТАХ-ээг төсөвт суулгаснаас шалтгаалан төсөвт өртөгт өөрчлөлт орох, барилгын материалын үнэ нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Энэ нь барилга байгууламж, зам тээвэр, дэд бүтцийн ажлууд төлөвлөсөн онд бүрэн хэрэгжиж дуусахгүй байх, он дамжин хэрэгжих, удааширах, олон жилээр хэрэгжихгүй орхигдох зэргээр ажлын үр дүн бүтээмжид нөлөөлөх үр дагавартай байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5<sup>14</sup>-д шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ноглох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хувиарласан хэмжээнээс багагүй байна гэж заасан.

2022 онд шинээр эхлэх, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын 293,913.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 58.6-37,656.2 сая төгрөгөөр илүү, нийт 67,980.4 сая төгрөгөөр илүү баталсан байна. Тухайлбал:

- Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил /УБ хот, БЗД 26 дугаар хороо/ 2022-2023 онд хэрэгжих ТАХ, төсөвт өртөг 3,173.2 сая төгрөг, санхүүжих дүн 1,755.4 сая төгрөг /илүү баталсан 168.8 сая төгрөг/
- Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагууд, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн засварын ажил /УБ хот/ төсөвт өртөг 2,738.0, санхүүжих дүн 2,079.8 төгрөг /илүү баталсан 704.8 сая төгрөг/
- “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зах зээлд гаргаж, иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр /Улаанбаатар хот/ 2022-2023 онд хэрэгжих ТАХ, 5,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 3,000.0 сая төгрөг /илүү баталсан 500.0 сая төгрөг/
- Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт хийх ажилд төсөвт өртөг 77,260.4 сая төгрөг, санхүүжих дүн 76,195.4 сая төгрөг /илүү баталсан 37,565.2 сая төгрөг/

<sup>14</sup> 29.3.5. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

**Дүгнэлт:** 2022 онд хэрэгжүүлэх 401,621.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 1.3-18,119.7 сая төгрөгөөр дутуу, нийт 87,053.0 сая төгрөгөөр дутуу баталсан байна.

**В.1.1.4 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан уу?**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4<sup>15</sup>-т төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байхаар тусгасан ч 2022 онд хэрэгжиж дуусах 35,457.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 203 ТАХ-ний гэрээг 2022.10 дугаар сараас хойш байгуулсан. **Хавсралт №9**

**Хүснэгт №9. Төрийн хэмнэлтийн тухай хууль, журамд нийцээгүй ТАХ**

№	ТАХ-ний ангилал	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Эхлэх он	Дуусах он
1	Барилга байгууламж	19	23,858.1	2022	2022
2	Засвар	12	1,560.1	2022	2022
3	Их засвар	18	3,111.0	2022	2022
4	Тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж	150	4,249.9	2022	2022
5	тоног төхөөрөмж	2	90.0	2022	2022
6	Уулзвар, авто зам	1	2,500.0	2022	2022
7	Явган зам	1	88.6	2022	2022
<b>НИЙТ</b>		<b>203</b>	<b>35,457.7</b>		

Мөн хуулийн 13.1.5<sup>16</sup>-д хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байхаар заасан.

Гэтэл НЗД-ын захирамжаар 11 байршилд “Цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын 100 ор өргөө” цэцэрлэгийг шинээр барихаар зураг төсөвгүйгээр нэгжийн үнэ 647.3, нийт 7,120.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр төлөвлөн батлуулсан ч төсөвт өртөг нь магадлалаар /1 байршлын цэцэрлэгийн зураг төсөв 2022.12.23-ны 2669/2022 өдөр баталгаажсан/ баталгаажихад 414.6 сая төгрөг буюу 39.0%-иар өсч, нийт өртөг нь 1,061.9 сая төгрөг болж байна.

**Дүгнэлт:** Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримтлаагүй байна.

<sup>15</sup> 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

<sup>16</sup> 13.1.5. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;

## В.2 ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?

### В.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан уу?

НЗД 2022 онд харьяа 37 газарт 233 удаагийн захирамжаар 917,154.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 673 ТАХ-ний ХАА-ны эрхийг шилжүүлсэн.

/Тайлбар:НЗД-аас ТАХ-ний худалдан авах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ нэршил, байршил, хүчин чадал зэргийг нарийвчлан ТАХ-ний төсөвт өртгийг задлах, хуваах байдлаар шилжүүлсэн нь НИТХ-ын тогтоолд батлагдсан 179 багц ТАХ-ний тоон дүнг нь өсгөж 644 ТАХ болсон. НЗД-аас эрх шилжүүлсэн 644 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа ТАХ-г задалснаар 673 ТАХ болсон Мөн Захирамж гараагүй, тухай бүр захирамж гарах, өмнөх оноос шилжин хэрэгжих зэрэг 153,976.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.

Үүнээс 2022 онд 713,855.87 сая төгрөгийн төсөвтэй 596 ТАХ буюу 87.6%-ийн ХАА-г тухайн онд багтаан зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.

#### Хүснэгт №10. Эрх шилжүүлж, ХАА зохион байгуулсан

№	Эрх шилжсэн байгууллага	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ			ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ			
		Захирамж	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Шалгарсан өртөг	Хэмнэлт
1	ЗАА	8	14	8,435.0	11	4,700.0	2,153.0	2,547.0
2	НАЖГ	1	1	700.0	1	700.0	672.0	28.0
3	НБОГ	1	1	1,000.0	1			
4	НГЗБА	5	25	2,805.0	25	2,805.0	1,690.0	1,115.0
5	НД	3	21	1,310.0	21	1,310.0	1,280.0	30.0
6	НЗХГ	5	6	15,519.0	6	15,519.0	15,385.0	134.0
7	НОСБГ	5	11	22,446.0	6	18,613.0	18,504.0	109.0
8	НОСК	2	2	4,600.0	2	4,600.0	4,464.0	136.0
9	НӨХГ	2	2	400.0	2	400.0	324.0	76.0
10	НХААГ	53	43	281,280.6	64	317,281.0	304,104.6	13,176.4
11	НХБХГ	1	1	15.0	1	15.0	15.0	-
12	НХОГ	29	44	66,749.0	38	59,684.0	59,530.0	154.0
13	НЦУГ	3	3	800.0	3	800.0	800.0	-
14	НЦХМТГ	5	8	12,300.0	8	12,300.0	12,289.0	11.0
15	НЭМГ	1	2	500.0	2	500.0	497.0	3.0
16	УБНТНС	1	1	50.0	1	50.0	48.0	2.0
17	ЗТН ОНӨААТҮГ	1	1	2,300.0	1	2,300.0	2,298.0	2.0
18	ГУББГ ОНӨААТҮГ	1	1	3,300.0	1	3,300.0	3,300.0	-
19	ЗТГ ОНӨААТҮГ	1	1	600.0	1	600.0	589.0	11.0
20	УБЗЗАГ ОНӨААТҮГ	7	8	17,651.0	8	17,651.0	17,621.0	30.0
21	УБХАЗТБНТХНэгж ОНӨТҮГ	2	2	10,120.0	1	1,800.0	1,778.0	22.0
22	ХТГ ОНӨААТҮГ	6	38	25,664.0	38	25,664.0	21,483.0	4,180.0
23	ХТСИ ОНӨААТҮГ	2	2	927.0	2	927.0	927.0	-
24	ЭЭАҮП	2	4	6,440.0	4	6,440.0	6,352.0	88.0
25	УБХК	3	3	60.0	3	60.0	59.0	1.0
26	УБШББ ХХК	1	1	19,500.0	1	19,500.0	-	-
27	Ажлын хэсэг	13	87	190,276.2	58	143,887.0	141,562.4	2,324.6
28	БГД	5	50	4,549.0	40	4,016.0	3,919.9	96.0
29	БЗД	23	123	15,196.0	101	4,777.0	4,693.0	83.0
30	БНД	2	2	800.0	2	800.0	766.0	34.0
31	БХД	6	10	675.0	10	675.0	661.0	14.0
32	ЗХУТ	6	6	4,159.0	5	1,009.0	1,008.0	1.0
33	СБД	5	23	6,102.0	16	5,784.0	5,754.0	30.0
34	СХД	10	46	27,245.0	43	27,200.0	26,567.0	634.0
35	ҮЦХ	2	2	3,173.0	2	3,173.0	3,056.0	117.0
36	ХУД	5	72	5,150.0	61	4,635.0	4,419.0	216.0
37	ЧД	5	6	381.0	6	381.0	12.0	369.0
	<b>Нийт</b>	<b>233</b>	<b>673</b>	<b>763,177.8</b>	<b>596</b>	<b>713,856.0</b>	<b>668,580.9</b>	<b>25,774.0</b>


Харин 2022 онд 51,386.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 77 ТАХ дараах байдлаар хэрэгжиж дуусаагүй байна. Үүнд:

- 6,025.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ буюу 0.1%-ийн худалдан авах үнэлгээний хороо байгуулагдсан ч зураг төсөвгүй болон бусад шалтгаанаар төсвийн тодотголоор хөрөнгө нь хасагдаж ХАА зохион байгуулагдаагүй, хөрөнгө татагдсан.
- 45,361.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 68 ТАХ буюу 11.0%-ийн ТББ боловсруулах, үнэлгээ хийх зэргээр тухайн онд бүрэн дуусаагүй, 2022-2023 он дамжин үргэлжилж байна.

Эрх шилжсэн 763,177.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 673 ТАХ-ээс нийслэл дүүргийн худалдан авах ажиллагааны газарт 536 ТАХ буюу 80%, ОНӨААТҮГ-т 108 ТАХ буюу 16%, бусад харьяа газруудад 29 ТАХ буюу 4%-ийг худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

### **В.2.1.1 Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг зарласан уу?**

Гүйцэтгэгч нь сонгон шалгарсан 668,580.9 төгрөгийн гэрээний дүнтэй 596 ТАХ-г төрлөөр авч үзвэл авто зам, авто замын барилга байгууламж 38%, боловсрол 20%, төрийн үйлчилгээ 15%, хот тохижилт 9%, нийтийн тээвэр 9%, дэд бүтэц 7%-г тус тус эзэлж байна.



НЗД-аас 2022 онд шинээр хэрэгжиж эхлэх ТАХ-ний 673 ТАХ байна. Үүнээс 82% буюу 549 ТАХ-г 100 хүртэл хоногийн хугацаанд багтаан эрх шилжүүлсэн харин 18%-ийг буюу 124 ТАХ-г 100-аас илүү хоногийн хугацаанд буюу 2022.04.21-2022.12.16-нд эрх шилжүүлэх захирамж гаргасан байна. Тухайлбал:

- НЗД-ын 2022.12.16-ны А/1573 захирамжаар 1,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-ны эрхийг НХААГ-т эрхийг шилжүүлсэн ч 7 ТАХ нь ондоо багтаж гэрээ хийгдээгүй;
- НЗД-ын 2022.10.11-ны А/1312 захирамжаар 2,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны Товчооны замын уулзварын инженерчлэл болон Товчооны замаас урагш хийгдэх авто зам” ТАХ-ны эрхийг НЗХГ-т эрхийг шилжүүлсэн ч зураг төсөв, ажлын даалгаваргүйгээс ХАА он дамжин үргэлжилж байна.
- НЗД-ын 2022.08.04-ны А/1028 захирамжаар 694.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ-ны эрхийг НХААГ-т эрхийг шилжүүлсэн. Эдгээр ТАХ-г хэрэгжүүлэх онцлогоос хамааран багц болгон задалсан бөгөөд 2022.11.04 хүрэхэд 30% гүйцэтгэгч сонгон шалгараагүй байна.
- НЗД-ын 2022.08.04-ны А/1027 захирамжаар 73.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний эрхийг НХААГ-т шилжүүлсэн. 2022.12.06-ны өдрийн байдлаар 3 ТАХ нь тендерийн нээлт хийсэн ч компани материал ирүүлээгүй тул цуцлагдсан. Дахин зарлахаар ТББ боловсруулж байна.
- НЗД-ын 2022.11.21-ны А/1474 захирамжаар 973.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ-ны эрхийг СХД, ХУД, БЗД-ийн ХААА-нд эрхийг шилжүүлжээ.

НЗД-ын 233 удаагийн захирамжаар ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулах эрхийг харьяа 31 байгууллага, 6 дүүргийн ЗД-д эрх шилжүүлж захирамжилсан байна.

Эрх шилжүүлсний дараа ХАА-г зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдаж байгаа ч зарим ХАА-ны үнэлгээний 100 хоногийн дараа байгуулагджээ. Тухайлбал:

- НЗД-ын 2022.03.14-ний А/383, 2022.07.01-ний А/931 захирамжаар “Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (СХД, 13 дугаар хороо)” ТАХ-г НХААГ-т эрхийг шилжүүлсэн. Үнэлгээний хороо 158 хоногийн дараа буюу 2022.10.26-ны өдөр байгуулсан.

- Үнэлгээний хороод байгуулагдсан ч газрын зөвшөөрөл, зураг төсөв, зургийн даалгавар, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон холбогдох баримт материал нь дутуу, боловсруулагдаагүй байсан зэрэг шалтгаанаар нийт 69 ТАХ, үүнээс 14 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж эхлэхэд 200-с дээш хоног, 55 ТАХ 100-200 хоногийн хугацаа алдсан байна. Хавсралт №1 НЗД-ын 2022.03.14-ний А/383, 2022.07.01-ний А/931 захирамжаар “Дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (СХД, 13 дугаар хороо)” ТАХ-г НХААГ-т эрхийг шилжүүлсэн. Үнэлгээний хороо 158 хоногийн дараа буюу 2022.10.26-ны өдөр байгуулсан.

Үнэлгээний хороод байгуулагдсан ч газрын зөвшөөрөл, зураг төсөв, зургийн даалгавар, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт болон холбогдох баримт материал нь дутуу, боловсруулагдаагүй байсан зэрэг шалтгаанаар нийт 69 ТАХ, үүнээс 14 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж эхлэхэд 200-аас дээш хоног, 55 ТАХ 100-200 хоногийн хугацаа алдсан байна. **Хавсралт №10**

Тендерт оролцогчдын ерөнхий нөхцөл, санхүүгийн чадавх, техникийн болон туршлагын шаардлага хангаагүй, тендер ирүүлээгүй зураг, төсөв зөрүүтэй, НЗД-аас цахим системээр эрх шилжүүлээгүй зэрэг шалтгаанаар 35 ТАХ-ний ХАА 5-10 удаа зохион байгуулагдсанаас хугацаа хойшлогдсон байна. **Хавсралт №11**

**Дүгнэлт:** НЗД-аас 2022 онд шинээр хэрэгжиж эхлэх ТАХ-ний 549 ТАХ буюу 82%-ийг нь 100 хүртэл хоногийн хугацаанд багтаан эрх шилжүүлсэн, 124 ТАХ буюу 18%-ийг 100-аас дээш хоногийн дараа шилжүүлсэн байна.

### **В.2.1.3 Гүйцэтгэгчийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан уу?**

Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 439,549.1 сая гэрээний дүнтэй 131 ТАХ, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар 3,225.23 төгрөгийн гэрээний дүнтэй 16 ТАХ, тендер шалгаруулалтын онцгой журмаар 72,715.13 сая төгрөгийн гэрээний дүнтэй 370 ХАА-ны гүйцэтгэгч сонгон шалгарч, амжилттай болсон

#### **Хүснэгт №11. ХАА-нд мөрдсөн журам**

Эх үүсвэр	ХАА-нд мөрдөгдсөн журам, арга	ТАХ-ний тоо	Шалгарсан өртөг
Их засвар	НТШ	47	17,724.47
	ТШОЖ	10	560.62
	ЗҮ ТСШЖ	15	2,255.23
НТХО	НТШ	50	196,105.57
	ТШОЖ	104	2,866.21
	Шууд захирамж	3	4,227.10
	Хуулийн 3.4	66	117,377.12
	ЗҮ ТСШЖ	1	970.00
Түгжрэл	НТШ	34	225,719.06
	ТШОЖ	256	69,288.3
	Шууд захирамж	10	31,487.30
<b>НИЙТ</b>		<b>596</b>	<b>668,580.99</b>

Аудитаар 2022 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 713,855.87 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 596 ТАХ-нээс 32% буюу 322,596.67 сая төгрөгийн төсөв өртөгтэй 192 ТАХ-г түүвэрт хамруулан шалгахад 46 ТАХ буюу 59,996.6 сая төгрөг буюу 23.9%-д нь дараах зөрчлүүд илэрсэн.

#### **Нээлттэй тендер шалгаруулалтын журам:**

- НХААГ-аас зохион байгуулсан 2,026.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл

ажиллагаатай холбоотой заавар “**Амгалан цогцолбор сургуулийн халаалтын хэрэгсэл солих ажил БЗД 8-р хороо**” Төсөвт өртөг: 1,526.9 сая төгрөг, Гүйцэтгэгч “Баялаг говь” ХХК, /Тусгай зөвшөөрлийг тухай бүр өөрчилсөн/ “**Өрхийн эрүүл мэндийн төвийн засварын ажил СБД 1-10-р хороо**” Төсөвт өртөг: 500.0 сая төгрөг, Гүйцэтгэгч: ОДБНД ХХК /ТШЗ 17.7, 17.6.5 тусгагдсан шаардлагыг дахин нягталсан талаар үнэлгээний тэмдэглэлд тусгаагүй/; **Хавсралт №12**

- НЗХГ-аас зохион байгуулсан 1 ТАХ-ний “Дунд голын арын Алтай хотхоны урд талын авто зам” Төсөвт өртөг: 1,813.0 сая төгрөг, Гүйцэтгэгч: “Ихбогд зам” ХХК;
- НХААГ-аас зохион байгуулсан 27,700.4 сая төгрөгийн өртөгтэй 12, НОСБГ-аас зохион байгуулсан 6,590.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, нийт 38,237.8 сая төгрөгийн өртөгтэй 13 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12.3-т заасан ТББ-т тусгасан санхүү, боловсон хүчин, техникийн чадавхи, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй, ТББ-т тусгасан шаардлага хангаагүй оролцогчдыг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан; **Хавсралт №13**

#### **Шууд гэрээ байгуулах журам:**

- НЗД-аас нийт 3 удаагийн захирамжаар “ХТГ” ОНӨААТҮГ-т 23,432.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-г ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.12<sup>17</sup>-д заасан үндэслэлээр шууд гэрээ байгуулсан. Гэтэл “ХТГ” ОНӨААТҮГ нь дээрх ажлыг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн 34.2<sup>18</sup>, 34.3<sup>19</sup>-д заасныг дагаж мөрдөөгүй, 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй магадлаагүй, “Ажил гүйцэтгэх гэрээ”-г гүйцэтгэгчидтэй байгуулсан байна.
- НЗД нийт 2 удаагийн захирамжаар “УБЗЗАГ” ОНӨААТҮГ-т 9,181.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ эрх шилжүүлж, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3.12<sup>20</sup>-д заасан үндэслэлээр шууд гэрээ байгуулж, 6,560.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-г дүрмээр хүлээсэн үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн, 2,621.4 сая төгрөгийн 2 ТАХ-нд тус ажлыг хэрэгжүүлэх туслан гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн 34.2<sup>21</sup>, 34.3<sup>22</sup>-д заасныг дагаж мөрдөөгүй, “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан байна. **Хавсралт №14**

#### **Харьцуулалтын арга:**

- НЗД-ын захирамжаар эрх шилжүүлж, 1,813,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 багц /задарсанаар 311/ ТАХ-ний ХАА-г зохион байгуулахыг нийслэлийн 7 дүүргийн ЗД-т, захиалагчын хяналт хэрэгжүүлэхийг НБГ-д даалгасан. Цагалбарын хувьд ижил цаг хугацаанд тендер зарлагдсан бөгөөд НБГ-аас тус ТАХ-нүүдийг зохион байгуулах ажлын даалгавар техникийн тодорхойлотыг

<sup>17</sup> 3.12.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

<sup>18</sup> Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

<sup>19</sup> Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

<sup>20</sup> 3.12.Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

<sup>21</sup> Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

<sup>22</sup> Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

дүүргүүдэд хүргүүлэхдээ ТБОНӨБАУХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5<sup>23</sup>дахь заалтыг зөрчсөн төсөвт өртгийг задалсан. Тухайлбал:

**Хүснэгт №12. ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа нэршил, байршил, хүчин чадал зэргийг нарийвчлан төсөвт өртгийг задлах, хуваасан бөгөөд багцалсан ТАХ**

№	Захирамж ийн дугаар	Эрх шилжүүлсэн байгууллага	ТАХ-ийн нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг (сая төг)	ТАХ-ий нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр
1	A/964 A/1028	БЗД	172 дугаар цэцэрлэгийн түрээсийн байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж	42.0	Тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх дүүрэг, 22, 122, 172 дугаар цэцэрлэг/ Тавилга багц1	37.0	Интерворлд ххк
2	A/964 A/1028	БЗД	22 дугаар цэцэрлэгийн бүлэг нэмэхэд шаардагдах тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж	15.2	Тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх дүүрэг, 22, 122, 172 дугаар цэцэрлэг/ Гал тогооны тоног төхөөрөмж/дотоодын/ багц2	10.2	Чиглэл ххк
3	A/964 A/1028	БЗД	122 дугаар цэцэрлэгийн бүлэг нэмэхэд шаардагдах тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж	10.1	Тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх дүүрэг, 22, 122, 172 дугаар цэцэрлэг/ Гал тогооны тоног төхөөрөмж багц3	3.2	
					Тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах /Баянзүрх дүүрэг, 22, 122, 172 дугаар цэцэрлэг/ Тоног төхөөрөмж багц4	16.9	Би си Ти ххк
НИЙТ ДҮН				67.3		67.3	

- Эдгээр ТАХ-ээс 1,813.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20 ТАХ-нд /задарсанаар 89 ТАХ /“Чиглэл” ХХК, 1,576.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20 ТАХ-нд /задарсанаар 46 ТАХ / “Интерволд ХХК”, 236.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 13 ТАХ-нд /задарсанаар 16 ТАХ/ “Нэкстдистрибьюшн” ХХК гүйцэтгэгчээр сонгон шалгарсан байна.

**Хүснэгт №13. Цэцэрлэгийн хүртээмж, нэмэгдүүлэх тоног, төхөөрөмж тавилга хэрэгсэл**

№	Дүүргүүд	ТАХ-ийн тоо	НЗД-аас эрх шилжсэн захирамж		Үнэлгээний хороо байгуулсан огноо	Урилга нийтэлсэн эхний огноо
			Дугаар	Огноо		
1	БГД ХАА	14	A/1027	2022.08.04	2022.08.08	2022.08.10
		22	A/1231	2022.09.26	2022.09.28	2022.10.04
		12	A/1028	2022.08.04	2022.08.09	2022.08.23
2	БЗД ХАА	33	A/1231	2022.09.26	2022.10.07	2022.10.10
		60	A/1119	2022.08.25	2022-08-29	2022.08.30
		8	A/1029	2022.08.04	2022.08.10	2022.08.19
3	СХД ХАА	16	A/1231	2022.09.26	2022.09.30	2022.11.15
		9	A/1030	2022.08.05	2022.08.05	2022.08.12
		7	A/1231	2022.09.26	2022.09.28	2022.09.29
4	СБД ХАА	26	A/1031	2022.08.04	2022.08.10	2022.08.12
		36	A/1231	2022.09.26	2022.09.28	2022.10.07
5	ХУД ХАА	9	A/1033	2022.08.04	2022-08-08	2022.08.10
		11	A/1231	2022.09.26	2022.09.27	2022.09.28

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллах, зөрчил гаргасан НЗД-ын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн гишүүд, НХААГ, НБГ, ХТГ, “УБЗЗАГ” ОНӨААТҮНГ зэрэг газрын албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

<sup>23</sup> 8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

**Дүгнэлт:** ХАА-г зохион байгуудахдаа оролцогчдыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаагүй, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.

## **В.2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй байна уу?**

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр өмнөх оноос дамжин болон 2022 онд шинээр эхэлсэн нийт 970,784.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 659 ТАХ-д “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, НБГ, НЗДТГ, ЗАА, НӨХГ, НХБХГ, НГЗБА, НЦХМТГ, ННТГ, УСУГ, УБ-Лифт зэрэг 32 газраас захилагчийн хяналт хэрэгжүүлжээ.

### **Хүснэгт №14. ТАХ-ний гэрээний хэрэгжилт**

№	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн	ТАХ-ний				Үүнээс				2022 онд эхлээгүй	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан		Дуусаагүй		Тоо	Гэрээний дүн
						Тоо	Гэрээний дүн	Тоо	Гэрээний дүн		
1	ЗАА	4	5,443.4	2	3,827.2			2	3,827.2		
2	НХОГ	332	634,638.4	251	557,306.9	138	348,769.5	113	208,537.4		
3	НЗХГ	34	272,739.4	27	172,434.2	7	9,809.4	11	141,936.6	9	20,688.1
4	НАГ	1	160.6	1	159.9			1	159.9		
5	НБГ	155	7,417.5	246	6,212.6	180	3,419.0	60	2,581.0	6	212.6
6	НБСШТ	1	1,800.0								
7	НГЗБА	6	90,524.2	6	62,714.7			6	62,714.7		
8	НЗДТГ	3	150.0	3	150.0	3	150.0				
9	ННТГ	2	77,260.4	2	76,195.0			2	76,195.0		
10	НОБГ	4	514.4	2	309.9			2	309.9		
11	НОСБГ	4	45.3								
12	НӨХГ	6	620.0	6	524.4	2	67.4	4	475.00		
13	НСУГ	1	50.0	1	48.4	1	48.4				
14	НУБГ	1	423.0	1	350.8					1	350.8
15	НУБХАЗТБНТНэгж ОНӨТҮГ	3	5,018.8	2	3,217.5					1	970.0
16	НХБХГ	23	3,579.8	23	3,408.8	7	15.0	16	3,393.8		
17	НХОГ, НБГ	1	200.0	1	200.0			1	200.0		
18	НХОГ, ХБХГ	1	727.1	1	727.1			1	727.1		
19	НЦУГ	1	7,526.8	1	7,526.8	1	7,526.8				
20	НЦХМТГ	20	22,081.2	20	22,081.2						
21	НЦХМТГ,ЗХУТ	2	1,187.6	2	1,178.6			2	1,178.6		
22	НЭМГ	3	4,974.0	3	4,935.6	3	4,935.6				
23	СХД	14	26,272.9	8	17,956.0			8	17,956.0		
24	Төслийн нэгжүүд	1	32,000.0	1	27,976.9					1	27,976.9
25	УБ лифт ОНӨААТҮГ	13	1,861.0	2	271.1			2	271.1		
26	УБХК	3	60.0	3	59.4	3	59.4				
27	УСУГ	2	783.0	2	772.0			2	772.0		
28	ХБХГ	1	200.0	1	200.0					1	200.0
29	ЭЗАҮП НӨААТҮГ	2	40.0								
	<b>НИЙТ</b>	<b>644</b>	<b>1,198,299.1</b>	<b>659</b>	<b>970,784.3</b>	<b>345</b>	<b>374,800.5</b>	<b>233</b>	<b>312,697.9</b>	<b>19</b>	<b>21,451.5</b>

Дээрх ТАХ-нүүдээс 374,800.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 345 ТАХ буюу 53.6% нь хэрэгжиж дууссан, 312,697.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 233 ТАХ буюу 36.2% нь дуусаагүй он дамжин хэрэгжиж байна. Харин 21,451.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 19 ТАХ буюу 2.9% нь 2022 онд хэрэгжиж эхлээгүй байна.

“Авто замын түгжрэлийг бууруулах” арга хэмжээний хүрээнд:

“Авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээ”-ний хүрээнд 837,005.3 сая төгрөгийн төсөвт өртөг, 411,811.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 47 багц ТАХ нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан төсөвт өртгийг задалснаар 318 ТАХ хэрэгжихээр байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын жагсаалтад автозамын түгжрэлийг бууруулах өмнөх онуудаас шилжих 130,651.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, шинээр хэрэгжих 706,354.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 310 ТАХ, нийт 837,005.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 411,811.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 316 ТАХ батлагдсаны 83.6% буюу 266 ТАХ шинээр эхэлж 2022 онд дуусахаар, 10.0% буюу 32 ТАХ 2023 онд, 6.3% буюу 20 ТАХ 2024 он хүртэл хэрэгжихээр байна.

Нийт ТАХ-ний 22% нь сургууль цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх, 18% нь газар чөлөөлөлт болон нийтийн тээврийн парк шинэчлэлт, 17% нь шинээр барих гол ба туслах зам, 6% нь яармаг дэд төвийн барилга, 4% нь явган болон дугуйн зам болон гараж, хайс хашаа буулгах ажил, 3% нь нийслэлийн хөгжлийн төслүүд, 30%-ийг уулзваруудын дахин инженерчлэл болон зогсоолын менежментийг сайжруулах, нийтийн тээврийн зогсоол барих, бусад ажлууд эзэлж байна.

Өмнөх оноос дамжин болон 2022 онд шинээр эхэлсэн нийт 648,119.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 381 ТАХ-д НБГ, НГЗБА, НЗХГ, ННТГ, НХОГ, НУБХАЗТБНТ Нэгж, СХД зэрэг 8 газраас с захилагчийн хяналт хэрэгжүүлсэн.

#### Хүснэгт №15 “Авто замын түгжрэл бууруулах” ТАХ-ний гэрээний хэрэгжилт

№	Захиалагчийн хяналт тавих байгууллага	ТАХ тоо		Гэрээлсэн ТАХ		Хэрэгжиж дууссан		Дуусаагүй		2022 онд эхлээгүй	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	НБГ	153	7,277.5	246	6,212.6	180	3,419.0	60	2,581.0	6	212.6
2	НГЗБА	2	73,524.6	2	46,191.6	1	46,026.0	1	165.6		
3	НЗХГ	19	264,653.6	20	170,755.8	7	9,947.4	8	140,843.4		
4	ННТГ	2	77,260.4	2	70,028.6			2	70,028.6		
5	НУБХАЗТБНТ Нэгж ОНӨТҮГ	3	5,018.8	3	4,995.3			2	3,217.5	1	1,777.8
6	НХОГ	114	377,797.7	89	328,334.7	30	39,190.8	59	289,143.9		
7	НЦХМТГ	19	19,081.2	10	14,259.7	10	14,259.7				
8	СХД	4	4,704.7	1	4,297.9			1	4,297.9		
	<b>НИЙТ</b>	<b>316</b>	<b>829,318.5</b>	<b>373</b>	<b>645,076.2</b>	<b>228</b>	<b>112,842.9</b>	<b>133</b>	<b>510,277.9</b>	<b>7</b>	<b>1,990.4</b>

Автозамын түгжрэлийг бууруулах чиглэлээр батлагдсан 837,005.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 316 ТАХ-нээс 130,651.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ нь өмнөх онуудаас хэрэгжиж эхэлсэн, 706,354.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 310 ТАХ нь шинээр эхэлсэн ТАХ байна. /Тайлбар: НЗД-аас ТАХ-ний худалдан авах, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэхдээ нэршил, байршил, хүчин чадал зэргийг нарийвчлан ТАХ-ний төсөвт өртгийг задлах, хуваах байдлаар шилжүүлсэн нь НИТХ-ын тогтоолд батлагдсан 47 багц ТАХ-ний тоон дүнг нь өсгөж 310 ТАХ болсон. НЗД-аас эрх шилжүүлсэн 310 ТАХ-ний худалдан авалт 458, захилагчийн хяналтыг байгуулахдаа ТАХ-г задалснаар 381 ТАХ болсон. Мөн нийт ТАХ-ээс 7,686.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4,032.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 арга хэмжээ нь хэрэгжиж эхлээгүй буюу төсөвт үлдсэн /хэрэгжүүлэх талаар захирамж гараагүй/ байна/

2022 онд 645,076.2 сая төгрөгийн дүнтэй 373 ТАХ-ний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Үүнээс 2022 онд 112,842.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 228 ТАХ буюу 17.5% нь бүрэн хэрэгжсэн, 510,277.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 133 ТАХ буюу 79.1% нь хэрэгжилтийн шатанд, 1,990.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ буюу 0.3% нь эхлээгүй байна.

Автозамын түгжрэлийг бууруулах 5 чиглэлийн дагуу хэрэгжүүлэх нийт 316 ажлын хэрэгжилт 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах явцтай байна. Үүнд:

1. Шинээр барих гол замын 4 ажлаас 3 ТАХ хэрэгжиж байгаа, 1 ТАХ эхлээгүй.
2. Шинээр барих туслах гудамж 7 ажлаас 3 ТАХ хэрэгжиж байгаа, 4 ТАХ бүрэн хэрэгжсэн
3. Бусад /уулзваруудын дахин инженерчилэл, газар чөлөөлөлт, замын хөдөлгөөн удирдлага зохион байгуулалтын ухалаалаг систем, явган болон дугуйн замын тохижилт, граш хайс буулгаж чөлөөлсөн газрын тохижилт, нийтийн тээврийн парк шинэчлэлт, дундын болон эцгийн зогсоол шинээр барих 44 ажлаас 7 ТАХ хэрэгжиж байгаа, 29 ТАХ бүрэн хэрэгжсэн, 8 ТАХ эхлээгүй
4. Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх 253 ажлаас /үүнээс цэцэрлэгийн зориулалтаар орон сууцны 1-р давхар худалдан авах 12ш, цэцэрлэгийн барилга 1, бие даасан барилга 17ш тус бүр худалдан авах, цэцэрлэгийн барилга өргөтгөх 5ш, засварлах 32ш, цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө 11ш, Иж бүрэн гэр цэцэрлэг 6ш, бага сургууль цэцэрлэгийн цогцолбор 9ш, 153 цэцэрлэгт

тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж/. 90 ТАН хэрэгжиж байгаа, 25 ТАН бүрэн хэрэгжсэн, 138 ТАН эхлээгүй

5. Ерөнхий боловсролын сургууль барих 10 ажлаас /1ш сургууль худалдан авах, шинээр 9 сургууль барих/ 8 ТАН хэрэгжилтийн шатанд, 1 ТАН бүрэн хэрэгжсэн, 1 ТАН эхлээгүй

Дараах ажлууд бүрэн хэрэгжиж дууссан. Үүнд:

- **Шинээр барих гол замын багц ажлын хүрээнд:** Шинээр 4 туслах зам ашиглалтад орсон байна. Үүнд:
  - Хайгуулчдын гудамж болон Хүнсчдийн гудамжны дагуу шинээр барих болон шинэчлэх авто зам;
  - Улаанхуарангийн гудамжнаас 68 дугаар сургуулийн баруун талаар Цагдаагийн академийн өргөн чөлөөтэй холбох гудамж зам;
  - Эрчим хүчний гудамжнаас Монос фарм трейд ХХК хүртэлх Таван толгой түлш ХХК-ийн зүүн талаар шинээр хийгдэх авто зам
  - Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх авто зам
- **Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийн хүрээнд:** Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус /224 ширхэг/ бүрэн нийлүүлэгдэж “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгсөн байна.
- **Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх ажлын хүрээнд:** Нийслэлийн авто замын 14 байршилд П шон угсарч суурилуулах, **камер болон RFID** төхөөрөмжөөр тоноглох, тохиргоо хийх, шилэн кабелийн сүлжээнд холбогдсон, авто замын гэрлэн дохиотой уулзваруудад **иж бүрэн шон угсарч суурилуулах**, засвар үйлчилгээний ажил бүрэн хийж гүйцэтгэгдсэн, нийслэлийн шалган нэвтрүүлэх **товчоодод цахим** төлбөр, хураамжийн системийг сайжруулах, төлбөрийн нэхэмжлэх үүсгэх, төлбөрийн нэгдсэн системд холбох, тоног төхөөрөмж угсарч суурилуулах ажил, тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний нэгдсэн портал **Smartcar.mn 3.0** хувилбарыг нэвтрүүлж, замын хөдөлгөөнд оролцогч нарт зам тээврийн олон төрлийн мэдээлэл өгөх, хөгжүүлэлт хийх ажлууд тус тус хийж гүйцэтгэгдсэн.
- **Түгжрэлийн бууруулах ажлын хүрээнд барих ерөнхий боловсролын сургуулийн хүртээмж нэмэгдүүлэх ажлын хүрээнд:** Сургуулийн барилга худалдан авах, 640 суудал УБ хот, БЗД-ийн 22 дугаар хороо. Төсөвт өртөг 5,098.0 сая төгрөг, Гүйцэтгэгч: Түмэн өргөө хаус ХХ

**Зураг 1. Дизель хөдөлгүүртэй автобус болон иж бүрэн шон /RFID/**



Дараах ажлууд хэрэгжилт дутуу байна. Үүнд:

- Шинээр барих гол замын барих ажлын хүрээнд: Гол зам барих томоохон гүүр, олон түвшний огтлолцлын ажилууд 2022-2024 онд дуусах бөгөөд газар чөлөөлөлт болон гүйцэтгэгч оройтож шалгарсан, хүйтний улиралд ажил эхэлсэнтэй холбогдуулан ажил хэрэгжилтийн шатандаа явж байна. Үүнд:
  - Зайсангийн төмөрбетон гүүрийн өргөтгөл, шинэчлэлт,
  - Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3у/м төмөрбетон гүүрийн барилга,
  - Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол

- Шинээр туслах гудамж барих ажлын хүрээнд: 2022 онд хэрэгжиж дуусах байсан боловч гүйцэтгэгч оройтож шалгарсан мөн газар чөлөөлөлвийн ажлууд бшрэн хийгдэж дуусаагүй улмаас ажил бүрэн дуусаагүй хэрэгжилтийн шатандаа байна. Үүнд:
  - Чингисийн өргөн чөлөөнөөс Баруун үйлдвэрийн гудамж хүртэлх авто зам, гүүрийн барилга
  - Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто зам
  - Дунд голын арын Алтай хотхоны урд талын авто зам
- Бусад багц ажлын хүрээнд: Авто зогсоол шинээр барих, шинэчлэх, менежментийг сайжруулах, төлөвлөлтийг дахин зохион байгуулах ажил /Их багтаамжийн зогсоол шинээр барих, менежментийг сайжруулах/ (төсөвт өртөг 8,319.6 сая төгрөг) гүйцэтгэгч шалгараагүйгээс ажил эхлээгүй.
- Товчооны замын уулзварын инженерчлэл болон Товчооны замаас урагш хийгдэх авто замын ажил СХД-ийн 32 дугаар хороо төсөвт өртөг 2,500.0 сая төгрөг гүйцэтгэгч: “УБЗЗАГ” ОНӨААТҮГ зураг төсөв дахин хийгдэж байгаа, газар чөлөөлөлт хийгдэж байна.
- Цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх багц ажлын хүрээнд: Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200 ор (Сүхбаатар дүүрэг, 10 дугаар хороо, 234 дүгээр цэцэрлэг) (төсөвт өртөг 3,473.8 сая төгрөг) үнэлгээний явцад гомдол ирж, гомдлыг 2022/10/12-ны өдөр шийдвэрлэсэн. Гэрээ хийгдэх шатандаа явж байна.
- Цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх багц ажлын хүрээнд: 111 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (Сонгинохайрхан дүүрэг, 1 дүгээр хороо) (төсөвт өртөг 647.3 сая төгрөг) ажлын загвар зураг гараагүйгээс ажил эхлээгүй,
- Ерөнхий боловсролын сургууль барих багц ажлын хүрээнд: Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 30 дугаар хороо/ (төсөвт өртөг 9723.4 сая төгрөг) ТАХ-ний газрын асуудал шийдвэрлэгдээгүй. Сангийн яаманд гомдол гарч ХАА-г түдгэлзүүлж дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн.
- Автозамын түгжрэлийг бууруулах нийт ажлаас 2022 онд бүрэн хэрэгжиж дуусах 63,204.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 115 ТАХ буюу 51% нь эхлээгүй, 27 ТАХ буюу 12% нь бүрэн хэрэгжсэн байна.

Аудитаар 829,318.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 316 ТАХ-г хамруулан төсөл арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэсэн эсэхийг баримт материалтай тулган баталгаажуулалт хийхэд гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж ажиллаагүй дараах зөрчил илэрсэн. Тухайлбал:

### **НЗХГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:**

- Шинээр барих гол замын багц ажлын хүрээнд: Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол. Төсөвт өртөг 84,359.0 сая төгрөг /ТАХ-нд гүйцэтгэгч оройтож шалгарсан буюу 2022.12.22-нд гэрээ байгуулсанаас шалтгаалан зам барилгын ажил эхлээгүй.
- Гачууртын авто замаас Шар хадны автобусны эцсийн зогсоол хүртэлх 4.27 км авто зам, Улиастай голын 97.3 у/м төмөрбетон гүүрийн барилга. Төсөвт өртөг 14,199.8 сая төгрөг /Ажил үргэлжиж байгаа. Тухайн замын трасст 101 нэгж талбар өртсөн замын нөлөөлөлөөс 37 нэгж талбарыг чөлөөлсөн ч 97.3 у/м гүүрийн трасс-д ЦДҮС-ТӨХК-ийн 110кВ-ийн өндөр хүчдэлийн агаарын шугам нь гүүрийн захын тулгуур нөлөөлөлд өртсөн. Зорчих хэсгээс дээшээ аюулгүйн зай хангагдахгүй байгаа тул зайлшгүй хүчитгэх анкер тулгуураар өндөрлөх шаардлага бий болсон.
- Номин Юнайтед их дэлгүүрийн баруун талын авто замаас Б.Шаравын гудамж хүртэлх авто зам. Төсөвт өртөг 1,462.0 сая төгрөг Гүйцэтгэгч “Мегатитан” ХХК, /өндрийг хэмжигч 2 байхаас 1 хэмжигч унасан/

## НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

Худалдан авахаар шийдвэрлэж гэрээ байгуулсан дараах бие даасан барилгууд Барилгын тухай хууль<sup>24</sup>, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин<sup>25</sup>, Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм<sup>26</sup>, дүрэм зэрэг шаардлагуудыг хангахгүй байна. Үүнд:

- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 280 ор /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 36 дугаар хороо/ Гэрээний дүн: 4,450.0, Нийлүүлэгч: Иргэн Ц.Ганхуяг /СӨБ-ын сургалтын орчны стандарт болон ажлын даалгаварт тусгасан нэг бүлэгт 20-25 хүүхэд байхаар байна. Гэтэл тус барилгын талбайн зохион байгуулалтыг нэг бүлэгт 35 хүүхэд байхаар тооцон 8 бүлэг гаргаж СӨБ-ын стандарт зөрчсөн/.
- Орон сууцны I давхар, 100 ор (Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо) худалдан авах гэрээний дүн 2,585.0 сая төгрөг. Нийлүүлэгч: “Хөх бүрдийн эх” ХХК. /ТАХ-ний хүрээнд 6 давхар 3 айлын орон сууц үйлчилгээний зориулалттай барилгын 2, 3, 4 давхрыг цэцэрлэгийн зориулалтаар худалдан авсан. Энэ нь СӨБ-ын стандартыг зөрчсөн, ТАХ-ний нэр, байршил зөрүүтэй /Орон сууцны 1 давхар 100 ор/, зориулалтыг өөрчлөн засварлахдаа мэргэжлийн байгууллагаар зураг төсөл гаргуулж дүгнэлт гаргуулаагүй, гал тогоо нь стандартын шаардлага хангаагүй, гадна орчинд хүүхэд сурч, хүмүүжих нөхцөлгүй, хүүхдийн тоглоомын талбайгүй/
- Цэцэрлэгийн зориулалтаар “Бие даасан барилга, 150 ор (Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо) худалдан авах. Гэрээний дүн: 2,073.6 сая төгрөг. Нийлүүлэгч: Иргэн Д.Энхбат /Худалдан авсан барилгын ажлын зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлтгүй/
- Бие даасан барилга, 75 ор (Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо) Гэрээний дүн: 1,600.0 сая төгрөг: Нийлүүлэгч: Иргэн С.Дашмаа. /Барилгын ажлын зураг төсвийг, магадлалаар баталгаажуулаагүй, барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлтгүй, хуучин барилгыг мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл, дүгнэлтгүйгээр хоёр давхар болгосон, нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ стандартын шаардлага хангахгүй, агааржуулалтын системгүй, дулаан алдагдал ихтэй, угаалга хатаалга, урлаг заал, эмчийн болон ажилчдын хувцас солих өрөөгүй, аваарын гарц байхгүй, гал тогооны хуурай складгүй, төв замын хажууд байрлалтай, гадна хүүхэд тоглох тоглоомын талбайгүй/
- Бие даасан барилга, 50 ор (Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо). Гэрээний дүн: 1,600.0 сая төгрөг, Нийлүүлэгч:Иргэн Д.Одхүү. /Барилгын ажлын зураг, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй, барилга байгууламжийн байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлтгүй, нэг хүүхдэд ноогдох талбайн хэмжээ стандартын шаардлага хангахгүй, эмчийн болон ажилчдын хувцас солих өрөөгүй, аваарын орц гарц байхгүй, гадна хүүхэд тоглох тоглоомын талбай тохижилтгүй, гал тогооны хуурай складгүй, барилгын 3-р давхрын урлаг заал нь хүүхдийн аюулгүй байдал хангагдаагүй/
- Орон сууцны I давхар, 75 ор (Баянгол дүүрэг, 5 дугаар хороо). Гэрээний дүн: 918.0 сая төгрөг, Нийлүүлэгч:Иргэн Ц.Тулга. /Стандартын шаардлага хангахгүй 00 тосгууртай, хуучин ажиллаж байсан цэцэрлэгийн тавилга эд хогшлыг нүүлгээгүй, засвар хийж засаж сайжруулаагүй, захиалагчаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй/
- Орон сууцны I давхар, 50 ор (Сонгинохайрхан дүүрэг, 38 дугаар хороо). Гэрээний дүн: 530.1 сая төгрөг, Нийлүүлэгч: Иргэн н.Саруул /Хяналтын камерын тоо хэмжээг дутуу суурилуулсан, агааржуулалт байхгүй, захиалагчаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй/

<sup>24</sup> Барилгын тухай хуулийн 37.6 “Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.”, Барилга байгууламжид тавих шаардлага 14.1.Барилга байгууламж дараах шаардлагыг хангасан байна:14.1.1.зураг төслийн дагуу баригдсан байх;

<sup>25</sup> БНБД II-66-68-д цэцэрлэгийн эзэмшил газрын хэмжээг 90 хүртэл хүүхэдтэй бол нэг хүүхдэд 35м2 буюу 3510м2 байх, MNS6558: 2015

<sup>26</sup> Ерөнхий шаардлага, MNS6578:2016 гал түймрээс хамгаалах. Барилгын гадна талын суурин шат, Техникийн шаардлага БНБД II-66-68

- Орон сууцны I давхар, 50 ор Баянгол дүүрэг, 26 дугаар хороо. Гэрээний дүн: 500.3 сая төгрөг. Нийлүүлэгч: Иргэн Б.Нямсүрэн /Ажилчдын угаалгын өрөө цэцэрлэгийн хүүхдүүдийн угаалгын өрөөтэй хамт байрласан, хүүхдийн суултуур, гар угаалтуурын тоо стандартын хэмжээнд хүрээгүй/

**Зураг 2.** Орон сууцны I давхар, 100 ор (ХУД, 21 дүгээр хороо)



Тайлбар: Тус байрны 2,3,4 давхарт хүүхдийн цэцэрлэг, дотроо лифттэй, гадна орчны стандартын шаардлага хангаагүй

Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөл, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд үр дүнтэй гүйцэтгэсэн эсэхийг тулгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

### **ННТГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:**

Их багтаамжийн дизель хөдөлгүүртэй автобус 224 ширхэг худалдан авах. Төсөвт өртөг 60.560.4 сая төгрөг, Нийлүүлэгч “Шиамэн голдэн драгон бус” ХХК-тай гэрээ /дизель автобус нэг бүрийн үнэ 640,781 юань/. 2022.10.11-нд 03/01, 03/02 дугаар гэрээ байгуулж, гэрээнд нэмэлт өөрчлөлтийг нийлүүлэгдэх барааны хугацаанд өөрчлөлт орсноор 2022.11.10-нд шинэчлэгдэж байгуулсан. Гэрээнд заасны дагуу 2023.06.25-аас 2024.12.25-ныг хүртэлх хугацаанд нийлүүлэх гэрээний хуваарьтай ч 2023 оны 03 дугаар сард багтаан 224 автобус бүрэн нийлүүлэгдсэн.

- Автобуснууд бүрэн нийлэгдсэн ч техникийн тодорхойлолтод заасан **“хөдөлгүүрийн эзэлхүүн 9000сс байхаар байхад 8400сс хүчин чадалтай нийлүүлэгдсэн”, “хурдны хайрцаг нь автомат гэж заасан байхад механик”, “хөгжлийн бэрхшээлтэй иргэний бууж, суух тусгай механик төхөөрөмжийг автоматжуулсан байхаар тусгасан ч гар ажиллагаатай”, “салхины шил нь 3 хэсэг бүхий ойролцоогоор 6мм-ын зузаантай аюулгүй наамал байна гэж заасан ч нүүрний шил ком, хажуугийн шил 1ком салдаггүй хийгдсэн”, “тээврийн хэрэгслийн урд, баруун хойд гэсэн гурван талд гадагш харсан нийтийн тээврийн хэрэгслийн чиглэлийг дугаар бүхий цахим хаяг дэлгэц нь дутуу суурилуудагдсан”, “дагалдах хэрэгслээр нийлүүлэх багаж хэрэгслийг дутуу нийлүүлсэн” Үүнд: Багаж -15, гудас-18, домкрат-10, ослын гурвалжин-27, шүүр тайлагч-4, шар ивүүр-12, хантааз-35%% хардны багаж-30, сүлжээний антени-30, нөөц дугуй 30/ зэрэг зөрчилтэй байна.**
- Хүүхдийн сургуулийн автобус төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт. Төсөвт өртөг 15,635.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Моннис моторс” ХХК-тай эхний гэрээг 2020.07.02-ны өдөр байгуулсан. Төсөвт өртөг 23,050.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тус гэрээнд заасны дагуу 2020 онд 75ш, 2021 онд 75ш, 2022 онд 50ш нийлүүлэх, нэгжийн үнэ 307,3 сая төгрөг. Уг гэрээг 4 удаа хугацаа сунгах гэрээгээр сунгасан бөгөөд 2022онд 50ш, нийт 75 автобус автобус нийлүүлэгдсэн. Гэрээнд автобусанд гүйцэтгэгч талаас нэмэлт тоноглол хийгдэхээр тусгасан хийгдээгүй байна. Үүнд: “Хүүхдийн цүнх гар тээш тавих тавиурыг 1 талд нь дутуу хийсэн”, “автобусны шал, гишгүүрийг резинэн материалаар бүрсэн байх гулгамтгай байж болохгүй заалтыг хэрэгжүүлээгүй резинээр бүрээгүй”, “суудлын бүрээс хөшиг хийгдээгүй”, “аваарын гарц байхгүй” зэрэг зөрчилтэй байна.

## НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаагаас барилгын ажлын чанар, ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй, хийгээгүй ажлын гүйцэтгэлийг баталгаажуулдаг дутагдал илэрч байна. Тухайлбал:

- Дараах 11 байршилд нэг бүрийн 647.3 сая төгрөг, нийт 7,120.3 сая төгрөгийн өртөг бүхий 100 ортой Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө-цомцог гэр барих ажлын гүйцэтгэлд дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- ХУД-ын 4, 14-р хороо, 12, 165 дугаар цэцэрлэгүүдийн дэргэд барих. /Цомцог гэр/ 2 байршилд барих 2 ТАХ. Гүйцэтгэгч: “Бумбод” ХХК /Гэрийн суурь, шалны бетон зэргийг цутгасан ч хүйтний улиралд горим зөрчиж хийснээс шалтгаалж хөлдсөн/.
- СХД-ийн 33-р хороо, 271 дүгээр цэцэрлэгийн дэргэд барих. Гүйцэтгэгч: “Бумбод ХХК” /Тус цомцог гэрийг ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад 2022 оны 9 дүгээр сараас цэцэрлэгийн зориулалтаар ашиглаж эхэлсэн/
- СХД-ийн 33-р хороо.188 дугаар цэцэрлэгийн дэргэд барих. Гүйцэтгэгч “Бумбод” ХХК /Зураг төсөв батлагдаагүй ажил эхэлсэн, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл байхгүй, гэрийн бүрээс, дулаалга шаардлага хангахгүй/
- СХД-ийн 1-р хороо.111 дүгээр цэцэрлэгийн дэргэд барих. Гүйцэтгэгч “Бумбод ХХК”, /барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл байхгүй, гэрийг зургийн дагуу байршуулаагүй, гэрийн бүрээс дулаалга шаардлага хангахгүй/

**Зураг 3.** 271 дүгээр цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө, 100 ор (СХД, 33 дугаар хороо) **Тайлбар:** Баригдсан гэрийн бүрээс тортогдож муудсан, дотроосоо чийг цохисон, зургийн дагуу баригдаагүй.



- СХД-ийн 113-р цэцэрлэгийн засвар. Төсөв өртөг: 85.0 сая төгрөг. Гүйцэтгэгч “ОДБНД” ХХК /нэг барилгын дээврийг хуулсан, бусад дээврийн засвар хийгдээгүй/
- БЗД-ийн 45-р цэцэрлэгийн барилгын засвар. Төсөвт өртөг: 77.4 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Голден прогресс” ХХК /Дээврийн усны хоолой эвдэрсэн, хугарч унасан/
- ХУД-ийн 9-р хороо. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга барих ажил. Төсөвт өртөг: 5,228.3 сая төгрөг, Гүйцэтгэгч: “Шунхлайн шандас” ХХК /Хашааны суурь цутгаж, халаалтын тогооны барилгын суурь угсарсан. Барилга угсралтын ажил хийгдээгүй, календарчилсан төлөвлөгөөнд тусгасан 2022 онд хийгдэх ажлууд хийгдээгүй, зохиогчийн хяналтын дүгнэлт, тайланг үндэслэн явцын гүйцэтгэл олгох шийдвэрлэсэн, ЗХ-ын зардалд 7.1 сая төгрөг олгосон/
- ХУД-ийн 12-р хороо. Нью Хабитат хороолол. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга барих ажил. Төсөвт өртөг: 4,576.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жавхлант Тур” ХХК /Өмнөх онд барилгын суурь угсарсан, календарчилсан төлөвлөгөөнд тусгасан 2022 онд хийгдэх ажлууд хийгдээгүй, тайланд онд БУА хийгдээгүй/
- ХУД-ийн 12-р хороо. Био комбинат. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор. Төсөвт өртөг: 4,656.8 сая төгрөг, Гүйцэтгэгч: “Нарангэрэл мандал” ХХК.

*/өмнөх онд барилгын суурь угсарсан, календарчилсан төлөвлөгөөнд тусгасан 2022 онд хийгдэх ажил хийгдээгүй, тайланд онд БУА хийгдээгүй*

- ХУД-ийн 14-р хороо. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор Хан-Уул дүүрэг, Төсөвт өртөг: 4,376.7 сая төгрөг, Гүйцэтгэгч: “Хөхий Хан” ХХК */Өмнөх онд барилгын суурь угсарсан, календарчилсан төлөвлөгөөнд тусгасан 2022 онд хийгдэх ажил хийгдээгүй/*

### **НБГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ТАХ:**

НЗД-ын 2022 оны эрх шилжүүлэх тухай А/1027,1028,1029, 1030,1031 дугаар захирамжуудаар цэцэрлэгийн байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоглоом нийлүүлэх 7,277.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 153 ажлын худалдан авах ажиллагааны эрхийг 6 дүүрэгт эрх шилжүүлэн хэрэгжүүлж, захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллахыг НБГ-т даагласан байна.

НБГ-ын даргын 2022 оны А/86, А/106, А/135 дугаар тушаалаар боловсролын салбарын хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод боловсруулж, захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, гүйцэтгэл үр дүнг хариуцан ажиллахыг даалгасан байна.

- Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлын даалгавар, **техникийн тодорхойлолтыг боловсруулж**, дүүргүүдэд хүргүүлэхдээ ТБОНӨБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5<sup>27</sup> дахь заалтыг зөрчсөн төсөвт өртгийг задалсан.
- Хүүхдийн цэцэрлэгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэхээр гэрээ байгуулсан “Онцгой өргөө” ХХК нь 957.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 ТАХ-г гэрээнд **заасан хугацаанд нийлүүлээгүй**. Гэрээнд заасан хугацаа хэтэрсэн боловч захиалагчийн хяналт хэрэгжүүлж гэрээний заалтын дагуу алданги тооцож ажиллагаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3<sup>28</sup>, Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1<sup>29</sup>, заалтуудыг зөрчсөн.
- Цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд дараах тоног төхөөрөмжүүд */хүүхдийн ширээ, сандал, башгийн ширээ сандал, вандан сандал, хивсэн дроз, гал тогооны тавилга, хэрэгсэл, тоглоомын тавиур, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, ажилчдын хувцасны шүүгээ, зөөврийн компьютер, принтер, тоос сорогч, ус буцалгагч/* нийлүүлэгдсэн байна.
- Хэрэгжиж дууссан 3,929.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 189 ТАХ-г газарт дээр нь очиж тулган баталгаажуулалт хийхэд дараах нийтлэг зөрчил илэрч байна. Тухайлбал:
- **Хүүхдийн ширээ** /техникийн тодорхойлолтод: MNS 004:1987 ... чанар стандартын шаардлагад нийцсэн тунгалаг, лакан болон гоёлын ламинар өнгөлгөөгөөр өнгөлсөн гоёлын ламинар, **модон хавтангаар**, хэмжээ нь зориулалтын **хуванцар материалаар** хийгдсэн, хүүхдийн аюулгүй байдалд тохирсон **цайвар шаргал** өнгөтэй... байна гэж заасан боловч нийлүүлэгдсэн ширээнүүд техникийн тодорхойлолтоос зөрсөн харилцан адилгүй байна.

**Зураг 4.**Цэцэрлэгүүдэд нийлүүлэгдсэн Хүүхдийн ширээ



<sup>27</sup> Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

<sup>28</sup> 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;

<sup>29</sup> 350.1.1.гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх;



- **Хүүхдийн сандал** /техникийн тодорхойлолтод: MNS 004:1987 ...**цайвар шаргал** өнгөтэй эсвэл **модны өнгөөр хийгдсэн**, углуурагдсан хийцтэй.. байна гэж заасан боловч харилцан адилгүй нийлүүлэгдсэн байна.

Зураг 5. Хүүхдийн сандал



- **Хүүхдийн хувцасны шүүгээ** /техникийн тодорхойлолтод: чанар, стандартын шаардлага хангагдсан тунгалаг, лакан болон гоёлын ламинар өнгөлгөөгөөр өнгөлсөн, ....**шүүгээний доод талд** шалнаас тусгаарлагч материалтай , **шалнаас 10-15 мм хөндий**, хаалга их биеийг сайн чанарын нугасаар бэхэлж, хаалганд **зориулалтын бариул** хийсэн байна гэж заасан боловч харилцан адилгүй, шалнаас тусгаарлагч стандартын дагуу биш, зарим шүүгээ зориулалтын бариулгүй нийлүүлэгдсэн.

Зураг 6. Хувцасны шүүгээ



- Мөн гал тогооны тавилга хэрэгсэл нийлүүлсэн “Чиглэл” ХХК-аас техникийн тодорхойлолтод заасны дагуу нийлүүлэгдээгүй, нийлүүлэгдсэн тавилга хэрэгслийн хүчин чадал зөрсөн. /40л-тэй тогоо нийлүүлэх байхад 60л-тэй нийлүүлэгдсэн, шалны зөөлөвчгүй нийлүүлэгдсэн.
- “Интерворлд” ХХК-аас хүүхдийн тоглоом нийлүүлэхдээ гэрээнд заасны дагуу хуваарийн дагуу нийлүүлээгүй, хэсэгчилж хүлээлгэн өгсөн.
- “Буриадын хаад” ХХК-аас тоног төхөөрөмж нийлүүлэхдээ комисс ажиллагүй байхад нийлүүлэлт хийсэн.

Хууль тогтоомжид заасан хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаагаас 957.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 22 ТАХ төсөвт тусгагдсаны дагуу ажлыг дутуу болон чанаргүй хийх зэргээг гэрээний хугацааг хоцроож, үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, захиалагчийн хяналтын явцад гардаг, алдаа зөрчлийг таслан зогсоож, шат шатны хяналт, үүрэг хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөгө болгон ажиллах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж эргэн мэдэгдэх хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Зураг 7. Цэцэрлэгийн хүртээмж нэмэгдүүлэх тавилга, тоног төхөөрөмж



Тайлбар: Гал тогоо тавилга нийлүүлэхдээ зэвэрсэн, хувцасны шүүгээ бариулгүй, тоглоом тоо хэмжээндээ бариулсан ч хуваарийн дагуу нийлүүлээгүй

### В.2.3. Санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон уу?

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр он дамжих болон шинээр хэрэгжих 1,345,953.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 179 багц ТАХ-нд /800 гүйцэтгэгч байгууллага/ 2022 онд 611,414.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, гүйцэтгэлээр 550 гүйцэтгэгчид 391,223.0 сая төгрөг буюу 64.0%-ийн санхүүжилт олгожээ. Үүнээс он дамжин санхүүжих 28 багц ТАХ /163 гүйцэтгэгч байгууллага/-нд гүйцэтгэлээр 35,971.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт №16. ТАХ-ний санхүүжилт

№	Эх үүсвэр	Тогтоолоор батлагдсан ТАХ-ний тоо	Багцаар задарсан		Санхүүжилт олгосон	
			Санхүүжилт олгох	Санхүүжсэн ТАХ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Нийслэлийн төсөв	80	234	152	337,187.6	143,632.2
2	Авто замын түгжрэл бууруулах	48	319	319	837,005.3	411,811.2
3	Их засвар	23	92	92	27,151.0	20,000.0
4	Он дамжсан	28	163	82	188,671.5	35,971.2
	<b>Нийт</b>	<b>179</b>	<b>808</b>	<b>645</b>	<b>1,390,015.4</b>	<b>611,414.6</b>

Санхүүжилтийг олгохдоо хууль журам, гэрээ, бодит гүйцэтгэлд үндэслэсэн эсэхийг шалгахад 3,626.9 сая төгрөгийн дүнтэй 5 ТАХ-нд бодит гүйцэтгэлээс илүү олгож, ЗГ-ын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.1.4<sup>30</sup>-д заасныг зөрчсөн. Үүнд:

- Цэцэрлэгийн зориулалтаар Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороонд иргэн Д.Ганбатын 2 давхар барилгыг 1,600.0 сая төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулсан, /Бие даасан барилга, 50 ор /Баянзүрх дүүрэг, 14 дугаар хороо/ тус барилга нь цэцэрлэгийн зориулалтаар ашиглах боломжгүй, барилга нь зураг төсөвгүй, магадлалаар баталгаажуулаагүй, улсын комисс хүлээн аваагүй, НХОГ-аас зориулалтын дагуу өөрчлөлт хийх талаар үүрэг даалгавар өгсөн ч биелэгдээгүй байхад 500.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Баткомплект ХХК-ны гүйцэтгэж байгаа 202 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ес заншлын өргөө, 100 ор /Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/ ТАХ-ний

<sup>30</sup> 4.1.4. Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төслийн зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.

гэрийн суурийн ажлаас өөр ажил хийгээгүй байхад 323.7 сая төгрөг буюу 50%-ийн санхүүжилт олгосон.

- Бумбод ХХК-ны гүйцэтгэж байгаа ХУД-ийн 4 болон 12 дугаар хороо, 122, 165 дугаар цэцэрлэгүүдийн дэргэд 100 ортой Монгол өв уламжлал, ес заншлын өргөө барих /цомцог гэр/ 2 ТАХ-ний гэрийн суурийн ажлаас өөр ажил хийгээгүй байхад ТАХ тус бүрд 323.7 сая төгрөг буюу 50%-ийн санхүүжилтийг олгосон.
- СХД-ийн 113 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажил. Гэрээний дүн: 85.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: ОДБДН ХХК нь дээврийн нэг байршлын хуучин дээврийг нь хуулснаас өөр ажил хийгдээгүй байхад 68.0 сая төгрөг буюу 80%-ийн санхүүжилт олгосон.

### Хүснэгт №17. Бодит гүйцэтгэлд үндэслээгүй илүү олгосон ТАХ

№	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт
1	Бие даасан барилга, 50 ор /Баянзүрх дүүрэг, 14 дугаар хороо/	1,600.00	500
2	202 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ес заншлын өргөө, 100 ор /Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/	647.3	323.7
3	12 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ес заншлын өргөө, 100 ор /Хан-уул дүүрэг, 4дүгээр хороо/	647.3	323.7
4	165 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ес заншлын өргөө, 100 ор /Хан-уул дүүрэг, 14 дүгээр хороо/	647.3	323.7
5	Цэцэрлэгийн засвар /СХД, 113 дугаар цэцэрлэг	85.0	68
<b>Нийт</b>		<b>3,626.9</b>	<b>1,538.9</b>

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д заасан “төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, ТБОНӨХБАУХАТХ-д заасан “барьцаа хөрөнгийн дансанд гэрээний үнийн дүнгийн 5-10%-ийг байршуулж болох” заалтыг зөрчин 14 ТАХ-ний 3,564.0 сая төгрөгийг төсвийн жил дуусахад 100% барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

### Хүснэгт №18. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Захиалагчийн хяналтын байгууллага	Төсөөт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн	(сая.төг) Гүйцэтгэлийн хувь
1	20 дугаар цэцэрлэгийн 2А дугаар байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж	НБГ	63.3	61.3	61.3	0%
2	115 дугаар цэцэрлэгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	47.5	46.0	46.0	0%
3	147 дүгээр цэцэрлэгийн А байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	51.4	51.0	51.0	0%
4	203 дугаар цэцэрлэгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	55.4	54.8	54.8	0%
5	21, 20 дугаар цэцэрлэгийн 1 дүгээр байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	47.5	26.8	26.8	0%
6	209, 218 дугаар цэцэрлэгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	47.5	46.0	46.0	0%
7	223, 209 дүгээр өргөө цэцэрлэгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	47.5	46.0	46.0	0%
8	243 дугаар цэцэрлэгийн 1, 2 дугаар байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	47.5	46.0	46.0	0%
9	27 дугаар цэцэрлэгийн 1, 2 дугаар байрны тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж Багц-1	НБГ	47.4	46.0	46.0	0%
10	Газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэх, хөрсний хурдатгал бичигч төхөөрөмж	НОБГ	225.0	195.5	195.5	0%
11	27 дугаар байрны цахилгаан шат шинэчлэх	УБ лифт ОНӨААТҮГ	140.0	135.2	135.2	0%

	ажил (БГД, 15 дугаар хороо)					
12	36 дугаар байрны цахилгаан шат шинэчлэх ажил (БГД, 11 дүгээр хороо)	УБ лифт ОНӨААТҮГ	140.0	135.9	135.9	0%
13	Бие даасан барилга, 150 ор /Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо/	НХОГ	2,073.6	2,073.6	2,073.6	0%
14	Бие даасан барилга, 75 ор /Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/	НХОГ	1,600.0	600.0	600.0	0%
<b>Нийт</b>			<b>4,633.6</b>	<b>3,564.0</b>	<b>3,564.0</b>	

2022 онд шинээр хэрэгжих 30,523.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-нд календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ажил хийгдээгүй байхад захиалагчийн хяналтын зардалд 292.6 сая төгрөгийг олгосон байна. Энэ нь СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 5.4<sup>31</sup>-д заасныг зөрчсөн байна.

### Хүснэгт №19. Ажил гүйцэтгэлд үндэслээгүй, хяналтын зардал гаргасан ТАХ

(сая.төг)

№	ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага	Төсөвт өртөг	2022 онд санхүүжсэн дүн	Захиалагчийн хяналтын зардал
1	Бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга, /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Нью хабитат хороолол/	НХОГ	6,095.1	499.9	78.4
2	Бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга, /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо, Биокомбинат/	НХОГ	6,095.1	500.0	75.9
